БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭЛТ ТОДОТГОЛ ХИЙЛГЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

- Тус үйлчилгээг үзүүлэх хүрээнд өмнөх онуудад хийгдсэн ажлын талаар мэдээлэл цуглуулах, цуглуулсан мэдээллийг боловсруулах,
- Төслийн Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан боловсруулах,
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамаар Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ гаргуулах,
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайланг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд заасны дагуу боловсруулах,
- Байгаль орчны менежментийн 5 жилийн төлөвлөгөөг Захиалагчтай зөвшилцөн боловсруулах,
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайланг БОАЖЯ-аар батлуулах зэрэг болно.

Төслийн товч танилцуулга ба ажлын цар хүрээ:

Туул голын гольдрил орд нь засаг захиргааны хувьд Төв аймгийн Заамар, Булган аймгийн Бүрэгхангай сумдын хил дээр дамнан оршдог. Улаанбаатар хотоос баруун урагш 240 км, Заамар сумын төвөөс хойш 30 км зайтай оршино.

Тус ордыг ил уурхайн аргаар ашигладаг бөгөөд тусгай зөвшөөрөлтэй талбайд драглайнаар олборлон баяжуулах үйл ажиллагаа явуулдаг. Уг ордын нөөцийг дахин батлуулж буйтай холбогдуулан төслийн ТЭЗҮ, БОНБНҮ-ний нэмэлт тодотголыг дахин хийх шаардлагатай болсон.

Энэхүү үнэлгээний тайлан боловсруулах ажилд үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай шууд холбоотой, үйлдвэрлэлийн явцад ашиглагдах түр болон байнгын барилга байгууламж, дэд бүтцүүдийг мөн хамруулна.

Иймд Гүйцэтгэгч нь дээрх зөвлөх үйлчилгээний тайланг боловсруулахдаа “Шижир-Алт” алтны үйлдвэрийн MV-000175 тусгай зөвшөөрөлтэй Туул голын гольдрил ордыг ашиглах төслийн хэмжээнд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах талаарх зөвлөмжүүдийг өгөх шаардлагатай.

Үндэслэл.

- Ашигт малтмалын тухай хууль;
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
- Бусад холбогдох журам, норм, стандартууд.

ХИЙХ АЖЛЫН БҮТЭЦ БА ДАРААЛАЛ, ҮНДСЭН ШААРДЛАГА.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний төслийг боловсруулахдаа дараах дараалаллын дагуу /гэхдээ эдгээрээр хязгаарлагдахгүй./ хийж гүйцэтгэнэ.

- Мэдээлэл цуглуулах, баталгаажуулах, бичиг баримтуудыг судлах;

- Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газар зүйн нөхцөлд хэмжилт судалгаа, дүгнэлт хийх,
- Геологийн тогтоц болон геоморфологийн хэмжилт судалгаа, дүгнэлт хийх,
- Уур амьсгал, ус, агаар, хөрс, ургамлан нөмрөг, амьтны аймаг, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийн судалгаа, дүгнэлт хийх, сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж өгөх
- Техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх шаардлагатай талбайн хэмжилт хийх; дүгнэлт гаргах, цаашид хийгдэх нөхөн сэргээлтийн ажлыг оновчлох, тооцоолох, төлөвлөх;
- Химийн бодисын эрдслийн үнэлгээ хийх, түүний нөлөөллийг бууруулах зөвлөмж өгөх,
- Байгалийн гамшгаас үүдэн гарч болзошгүй ослын үнэлгээ хийж, ослоос сэргийлэх, түүнийг багасгах, арилгах арга хэмжээг тодорхойлж тайланд тусгах
- Хэмжилтийн үр дүнгийн шинжилгээ, үнэлгээ өгөх, тооцоо судалгаа хийх;
- Судалгааны ажлын тайлан, сөрөг нөлөөллийг багасгах, нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөг багтаасан тайлан, бичиг баримтыг боловсруулан, Захиалагчтай зөвшилцөж, саналыг тусгах,
- Захиалагчтай зөвшилцөн эцэслэсний дараагаар БОАЖЯ-ны шинжээчээр хянуулж, зөвшөөрөл саналыг авах, Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах.
- Эцсийн тайланг 2 хувь үйлдэж, Захиалагчид хүлээлгэн өгч, акт үйлдэнэ.

Судалгааны ажил гүйцэтгэх үедээ байгаль орчин, булаг, шандыг бохирдуулж гэмтээж болохгүй.

Бусад шаардлага.

- Тайлан, зөвлөмжийн бичиг баримт нь Захиалагчийн өмч болох ба түүний зөвшөөрөлгүйгээр гуравдах этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
- БОНБНҮ-ний нэмэлт тодотголын тайлан боловсруулах аж ахуйн нэгж, байгууллага нь шаардлагатай мэргэжилтэй боловсон хүчин, мэргэжлийн багаж тоног төхөөрөмжтэй байна.
- Ашиглаж байгаа багаж, хэрэгслэлүүд нь тогтоогдсон тохируулга, магадалгаа хийгдсэн, батламжтай байна.
- Төслийн судалгааны ажлын тайлан, дүгнэлт, зөвлөмжүүдийн бичиг баримтын бүрдүүлэлт бичвэр нь олон улс болон Монгол Улсад мөрдөгдөж буй стандарт, дүрэм журмын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэнэ.
- Гүйцэтгэгч нь зохих шатны хяналтын байгуулагуудад танилцуулах, зөвшилцөх шаардлагатай бичиг баримтуудыг бүрдүүлнэ.
- Тайлангийн баримтад тусгагдах техникийн болон бусад шийдлүүдийг судалгааны ажлын явцад Захиалагчтай зөвшилцөнө.

ХАВСРАЛТ №2 - ТАЙЛАН ГАРГАХ ХУВААРЬ

Эцсийн тайланг төслийн ТЭЗҮ-г хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор боловсруулж, Захиалагчид хүлээлгэн өгнө.